

МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэх эрх олгох үйл ажиллагаа нь 7-р сарын 3-наас 7-р сарын 9-ныг дуустал орон даяар <http://burtgel.num.edu.mn/> хаягаар явагдана. Элсэх эрх олгох үйл ажиллагаа нь дараах дарааллын дагуу системд явагдана. Үүнд:

1. Системд нэвтрэх, ЭЕШ-ын оноо харах
2. Элсэгчийг шалгаруулах ба мэдэгдэх
3. Элсэх эрхээ баталгаажуулах, татгалзах
4. Элсэх эрхээ баталгаажуулах төлбөр төлөх
5. Элсэх эрх баталгаажсан эсэхийг шалгах

## 1. СИСТЕМД НЭВТРЭХ, ЭЕШ-ЫН ОНОО ХАРАХ

МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэлтийн системд нэвтрэхдээ **Үндсэн нүүр** цэс дэх нэвтрэх хэсэгт **Боловсролын үнэлгээний Төв /БҮТ/-ийн** системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үг ашиглан нэвтэрнэ. Бүртгүүлэгч нь бүртгэлийн дугаар, нууц үг, зурган кодыг том жижиг үсгийн ялгаатайгаар оруулж **Нэвтрэх** товч дээр дарна.

The screenshot shows the login interface of the Burtgel system. At the top, there is a header with the text "БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЭЛСЭЛТИЙН СИСТЕМ" and a user role indicator "Харгаллагчийн нэр". Below the header is a navigation menu with items: "Үндсэн нүүр", "Бүрэлдэхүүн сургууль", "Журам", "Гарын авлага", and "Холбоо барих". The main content area features a large image of a building with a "Нэвтрэх хэсэг" (Login section) callout. On the right side, there is a "Нэвтрэх" (Login) dropdown menu. Below it, there are input fields for "Бүртгэлийн дугаар" (Registration number) and "Нууц үг" (Password). A "Дарах" (Submit) button is located at the bottom right. A "Зурган код оруулах" (Enter CAPTCHA) button is also present. The page displays the number "987581" and a "Дээрх кодыг оруулна уу" (Enter the code above) prompt. Three callouts point to specific elements: "БҮТ-ийн системд нэвтэрдэг бүртгэлийн дугаар" (Registration number used for login in the BURT system), "БҮТ-ийн системд нэвтэрдэг нууц үг" (Password used for login in the BURT system), and "Дарах" (Submit).

МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэлт хааснаас хойш системд нэвтрэн орж **Үндсэн нүүрний** зүүн доод хэсгээс өөрийн ЭЕШ өгсөн хичээлийн оноо, гүйцэтгэлийг харна.

Дунгийн мэдээлэл		
Хичээлийн нэр	Гүйцэтгэл	Дүйцүүлсэн оноо
Математик	70	570
Монгол хэл	80	750

ЭЕШ-н оноо

### Санамж:

- МУИС-ийн элсэлтийн системд нэвтрэхгүй байгаа тохиолдолд БҮТ-ийн системд нэвтэрч үзнэ. Хэрвээ БҮТ-ийн систем рүү нэвтрэхгүй байгаа тохиолдолд БҮТ-д хандана. Хэрвээ БҮТ-ийн системд нэвтэрч байгаа боловч МУИС-ийн элсэлтийн системд нэвтрэхгүй байгаа тохиолдолд МУИС-ийн Мэдээллийн Технологийн Газар /77307730-1153,1151 МУИС-н номын сангийн 514 тоот/-тай холбоо барина уу.
- Бүртгүүлэгчийн хувийн мэдээлэл алдаатай байвал БҮТ-д хандана.
- Бүртгүүлэгчийн цахим шуудан, утасны дугаар өөрчлөгдсөн бол заавал шинэчилж хадгална.
- ЭЕШ-ын оноог БҮТ-өөс татаж авдаг учраас ЭЕШ-н оноотой холбоотой асуудлыг БҮТ-ээс лавлана уу.

## 2. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ БА МЭДЭГДЭХ

МУИС-н бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэлт хааснаас 1 өдрийн дараа элсэлтийн журмын дагуу нийлбэр онооны тооцооллыг бодож бүртгүүлэгчийн бүртгүүлсэн бүрэлдэхүүн/салбар сургууль тус бүрээр жагсаалт гаргана. Нийлбэр оноог бодохдоо бүртгүүлсэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн элсэлтийн шалгалтын хувилбарт таарах, босго онооны болзлыг хангасан хичээлүүдээс хамгийн өндөр оноотой хичээлүүдийг авч тооцоолол хийнэ (Бүрэлдэхүүн/салбар сургуулийн хувилбарт хамаарах "суурь" болон "дагалдах" хичээлийг харгалзах коэффициентээр үржүүлж хооронд нь нэмнэ). Хэрэв бүртгүүлэгчийн ЭЕШ-д өгсөн шалгалтын оноо нь тухайн бүртгүүлсэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн элсэлтийн шалгалтын хамаарах хувилбарт таараагүй, босго оноо даваагүй бол **одоогийн эзэлж буй байр** талбарт "Болзол хангаагүй" гэсэн утга гарна. Онооны жагсаалт гарсны дараа Нүүр хуудас дараах хэлбэртэйгээр харагдана.

Хувийн мэдээлэл	
Овог	Аав
Нэр	Хүү
Хүйс	Эрэгтэй
Регистрийн дугаар	ub12121212
ЕБ гэрчилгээний дугаар	0
Харъяалал	Завхан
Шалгалт өгсөн газар	Сүхбаатар дүүрэг
Сургууль	"Ханай" цогцолбор
Анги	00
Бүртгүүлсэн огноо	2015-04-01T00:00:00
Боломжит үлдээдэл	6000₮
Цахим шуудан *	Бүртгүүлсэн/салбар сургууль
Утасны дугаар *	
* Эцэсттэй холбоотой мэдээллийг хүлээн авахад ашиглагдана.	
Хадгалах	

**Бүртгүүлэгчийн анхааралд**

- Таны одоогийн эзэлж буй байр үлдсэн хяналтын тоонд багтсан үед таныг хяналтын тоонд багтсан гэж үзэн элсэх эрх нээгдэнэ /ногоон дэвсгэр өнгөөр ялгагдана/.
- Тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн жагсаалтанд таны одоогийн эзэлж буй байр үлдсэн хяналтын тоонд багтаагүй байсан ч жагсаалтын таны өмнөх бүртгүүлэгч өөр бүрэлдэхүүн/салбар сургуулийг сонговол таны эзэлсэн байр урагшилж үлдсэн хяналтын тоонд багтах магадлалтай.
- Элсэх эрхээ баталгаажуулахын тулд **БАТАЛГААЖУУЛАХ ЭЦСИЙН ХУГАЦААНААС ӨМНӨ** элсэх бүрэлдэхүүн/салбар сургуулийн өмнөх **СОНГОХ** баганад байрлах "○" -ийг сонгон **Баталгаажуулах** товч дээр дарж зохих төлбөрийг төлж баталгаажуулсан байна!
- Элсэх эрхээ баталгаажуулах төлбөрийн хэмжээ нь элсэн суралцах бүрэлдэхүүн/салбар сургуулийн 1 багц цагийн төлбөр байна. Тухайн төлбөр нь суралцагчийн сургалтын төлбөрт тооцогдоно.

Сайтар танилцах

**Баталгаажуулах**

№	Сонгох	Бүртгүүлсэн бүрэлдэхүүн/салбар сургууль	Суурь, дагалдах шалгалт (Тооцоолсон оноо)	Үлдсэн / Нийт хяналтын тоо	Одоогийн эзэлж буй байр	Баталгаажуулах эцсийн хугацаа	1 багц цагийн төлбөр	Үйлдэл
1		ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙМЛИЙН УХААНЫ САЛБАР	Математик, Монгол хэл (642)	0 / 0	1			Тухайн бүрэлдэхүүн/салбар сургуульд одоогоор эзэлж буй байр
2		ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР		/ 0				Жагсаалт харах
3		ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР	Математик, Монгол хэл (642)	1 / 1	1	2017-04-19 16:30:00	80200	Жагсаалт харах Татгалзах

Бүртгүүлсэн/салбар сургууль

Үлдсэн хяналтын тоо

Нийт батлагдсан хяналтын тоо

Нийлбэр оноо, нийлбэр оноог бодоход ашигласан хамгийн өндөр оноотой суурь болон дагалдах шалгалтын хичээл

ЭЭШ-н оноо

**Дүнгийн мэдээлэл**

Хичээлийн нэр	Гүйцэтгэл	Дүйцүүлсэн оноо
Математик	70	570
Монгол хэл	80	750

Бүртгүүлэгч бүртгүүлсэн бүрэлдэхүүн/салбар сургууль тус бүрдээ онооны жагсаалтад эзэлж буй байраа харахын тулд харгалзах **Жагсаалт харах** товч дээр дарна.

№	Сонгох	Бүртгүүлсэн бүрэлдэхүүн/салбар сургууль	Суурь, дагалдах шалгалт (Тооцоолсон оноо)	Үлдсэн / Нийт хяналтын тоо	Одоогийн эзэлж буй байр	Баталгаажуулах эцсийн хугацаа	1 багц цагийн төлбөр	Үйлдэл
1		ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	Математик, Монгол хэл (642)	0 / 0	1			<div style="border: 1px solid gray; border-radius: 5px; padding: 2px; display: inline-block;">Жагсаалт харах</div> <div style="border: 1px solid gray; border-radius: 5px; padding: 5px; display: inline-block; background-color: #007bff; color: white; margin-top: 5px;">Дарах</div>



**Улаанбаатар аймаг/хотын бүртгүүлэгчдийн жагсаалт**

Бүрэлдэхүүн/салбар сургууль: ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР

*(Таны байрлал шар дэвсгэр өнгөөр ялгагдана)*

№	Бүртгүүлэгчийн системийн дугаар	Оноо	%	Одоогийн эзэлж буй байр
1	2	642	74	1

Өөрийн эзэлж буй байр

Бүртгүүлэгчийн одоогийн эзэлсэн байр нь тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн үлдсэн хяналтын тоонд багтсан бол тухайн бүрэлдэхүүн/салбар сургуульд элсэх эрх нээгдэнэ. /ногоон дэвсгэртэй болно/

№	Сонгох	Бүртгүүлсэн бүрэлдэхүүн/салбар сургууль	Суурь, дагалдах шалгалт (Тооцоолсон оноо)	Үлдсэн / Нийт хяналтын тоо	Одоогийн эзэлж буй байр	Баталгаажуулах эцсийн хугацаа	1 багц цагийн төлбөр	Үйлдэл
3	<input type="radio"/>	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР	Математик, Монгол хэл (642)	1 / 1	1	2017-04-19 16:30:00	80200	<div style="border: 1px solid gray; border-radius: 5px; padding: 2px; display: inline-block;">Жагсаалт харах</div> <div style="border: 1px solid gray; border-radius: 5px; padding: 2px; display: inline-block; background-color: #e07a59; color: white; margin-top: 2px;">Татгалзах</div>

**Санамж:**

- Үлдсэн хяналтын тоонд багтсан эсэхээ бүртгүүлэгч бүртгэлийн системд байнга нэвтрэн шалгах шаардлагатай.
- Жагсаалтад таны эзэлсэн байр доогуур байсан ч та хяналтын тоонд багтах магадлалтай юм. Учир нь нэг элсэгч хэд хэдэн бүрэлдэхүүн/салбар сургуульд зэрэг бүртгүүлсэн ч зөвхөн нэг л бүрэлдэхүүн/салбар сургуульд элсэх боломжтой тул таны

өмнөх бүртгүүлэгч өөр бүрэлдэхүүн/салбар сургуулийг сонговол таны эзэлсэн байр дээшилж та үлдсэн хяналтын тоонд багтах боломжтой болно.

- Жагсаалт дахь нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд гүйцэтгэлийн хувиар байр эзлүүлэх ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана.

### 3. ЭЛСЭХ ЭРХЭЭ БАТАЛГААЖУУЛАХ

Бүртгүүлэгч тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн үлдсэн хяналтын тоонд багтсан, багтаагүй эсэх нь дараах өнгөөр ялгаран харагдана.

№	Сонгох	Бүртгүүлсэн бүрэлдэхүүн/салбар сургууль	Суурь, дагалдах шалгалт (Тооцоолсон оноо)	Үлдсэн / Нийт хяналтын тоо	Одоогийн эзэлж буй байр	Баталгаажуулах эцсийн хугацаа	1 багц цагийн төлбөр	Үйлдэл
1		ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	Математик, Монгол хэл (642)	0 / 0	1			Жагсаалт харах
3	<input checked="" type="radio"/>	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР	Математик, Монгол хэл (642)	1 / 1	1	2017-04-19 16:30:00	80200	Жагсаалт харах

Хяналтын тоонд багтаагүй

Хяналтын тоонд багтсан

Бүртгүүлэгч тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн үлдсэн хяналтын тоонд багтсан бол дараах үйлдлийг хийх боломжтой.

- Элсэх эрхээ баталгаажуулах

Бүртгүүлэгч нь тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн үлдсэн хяналтын тоонд багтаж элсэх эрх нээгдсэнээс хойш журамд заасан хугацаагаар бодогдсон баталгаажуулах эцсийн хугацааны дотор элсэх эрхээ баталгаажуулна. Баталгаажуулах эцсийн хугацаа нь элсэлтийн систем дэх баталгаажуулах эцсийн хугацаа талбарт харагдана. Хэрэв баталгаажуулах эцсийн хугацаанд элсэх эрхээ баталгаажуулаагүй бол элсэх эрхээсээ татгалзсан гэж үзэн тухайн бүртгүүлэгчийг уг жагсаалтаас хасаж жагсаалтын шугамын доор байгаа дараагийн бүртгүүлэгчид элсэх эрх шилжинэ.

Бүртгүүлэгч элсэх эрхээ баталгаажуулах бол элсэх бүрэлдэхүүн/салбар сургуулийн өмнөх **Сонгох** талбарт байрлах харгалзах нүдийг сонгон /доорх зурагтай танилцах / **Баталгаажуулах** товчийг дарна.

**Баталгаажуулах** товч дээр дарснаар бататгах асуултыг бүртгүүлэгчээс лавлан асууж зөвшөөрсөн тохиолдолд элсэх эрхээ баталгаажуулах үйлдэл нээгдэж **Үргэлжлүүлэх** товчийг дарж төлбөр төлөх хэсэгт шилжинэ.

**Баталгаажуулах** 1. Дарах

№	Сонгох	Бүртгүүлсэн бүрэлдэхүүн/салбар сургууль	Суурь, дагалдах шалгалт (Тооцоолсон оноо)	Үлдсэн / Нийт хяналтын тоо	Одоогийн эзэлж буй байр	Баталгаажуулах эцсийн хугацаа	1 багц цагийн төлбөр	Үйлдэл
3	<span style="border: 1px solid blue; padding: 2px;">2. Сонгох</span>	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР	Математик, Монгол хэл (642)	1 / 1	1	2017-04-19 16:30:00	80200	<span style="border: 1px solid black; padding: 2px;">Жагсаалт харах</span>

**Баталгаажуулах эцсийн хугацаа**

**Бүртгүүлэгчийн анхааралд**

Элсэх эрхээ баталгаажуулах

Та ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР бүрэлдэхүүн/салбар сургуулийг сонгон элсэх эрхээ баталгаажуулах гэж байна. Энэхүү бүрэлдэхүүн/салбар сургуульд элсэх эрхээ баталгаажуулсан тохиолдолд бусад бүрэлдэхүүн/салбар сургуулийн жагсаалтаас хасагдаж сонгох боломжгүй болох тул сонголтгоо нягтална уу!

Та ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР бүрэлдэхүүн/салбар сургуульд элсэх эрхээ баталгаажуулахыг зөвшөөрч байна уу?

Тийм. Баталгаажуулахыг зөвшөөрч байна.

4. Сонгох Үргэлжлүүлэх 3. Дарах

**Санамж:**

- Үлдсэн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч элсэх эрх олгох үйл ажиллагаа эхэлснээс хойш журамд заасан хугацаагаар бодогдсон баталгаажуулах эцсийн хугацааны дотор элсэх эрхээ баталгаажуулна. /заасан хугацаанд баталгаажуулаагүй тохиолдолд МУИС хариуцлага хүлээхгүй/.
- Бүртгүүлэгч хэд хэдэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн үлдсэн хяналтын тоонд багтсан бол зөвхөн нэг бүрэлдэхүүн/салбар сургуулийг сонгож элсэх эрхээ баталгаажуулна.
- Бүртгүүлэгч үлдсэн хяналтын тоонд багтсан бүрэлдэхүүн/салбар сургуульд элсэх эрхээ баталгаажуулахын тулд тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн 1 багц цагийн төлбөрийг төлнө. Энэ төлбөрийг суралцагчийн сургалтын төлбөрт тооцно. Элсэх эрхээ баталгаажуулах эцсийн хугацаандаа амжиж 1 багц цагийн төлбөрөө төлж баталгаажуулж чадаагүй бол элсэх эрхээсээ татгалзсан гэж үзнэ.



#### 4. ЭЛСЭХ ЭРХЭЭ БАТАЛГААЖУУЛАХ ТӨЛБӨР ТӨЛӨХ

**Үргэлжлүүлэх** товч дээр дарсны дараа бүртгүүлэгч элсэх эрхээ баталгаажуулахын тулд элсэн суралцах бүрэлдэхүүн/салбар сургуулийн нэг багц цагийн төлбөрийг төлж баталгаажуулалт хийнэ. Жишээ нь элсэгч Бизнесийн сургуульд элсэж байгаа бол Бизнесийн сургуулийн нэг багц цагийн төлбөрийг төлнө. Энэ төлбөр нь элсэн орсны дараа оюутны сургалтын төлбөрт тооцогдон орно.

Элсэх эрхээ баталгаажуулах бүрэлдэхүүн/салбар сургуулиа сонгосны дараа элсэлтийн журамд заасны дагуу бодогдсон төлөх төлбөрийн мэдээллийн хураамж хэсэгт гарна. Төлбөл зохих мөнгөн дүнг төлөх дараах 2 боломжтой. Үүнд:

- **Боломж 1.** Онлайн буюу цахим хэлбэр
- **Боломж 2.** PayBill үйлчилгээ

№	Бүрэлдэхүүн/салбар сургууль
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР

Элсэх эрхээ баталгаажуулах гэж байгаа сургууль

Төлбөр төлөх хэлбэр

Мөнгөн дүн

Төлбөр төлөх хэлбэрээ сонго

Хураамж: 80200 ₮  
Бэлнээр төлсөн: 1000 ₮  
Төлбөл зохих: 79200 ₮

Pay Billing

Онлайнаар төлөх

Онлайнаар төлөх

Дарах

Банкаа сонгоно уу

Голомт

[Голомт банкны салбараас интернэт пин код авна]

Хаан

[Хаан банкны салбараас интернэт пин код авна]

Хураамж төлөх банкаа сонгох

Төлбөрийг Голомт болон Хаан банкны төгрөгийн онлайн гүйлгээ хийдэг, өөрийн эзэмшдэг эсвэл өөр эзэмшигчийн (эзэмшигчийн зөвшөөрлөөр) картаар хийх боломжтой. Бусад банкны төгрөгийн картаар одоогоор хураамж төлөх боломжгүйг анхаарна уу. Бүртгэлийн хураамжаа төлөхийн өмнө онлайн гүйлгээ хийх интернэт PIN кодыг тухайн банкнаасаа авсан байх шаардлагатай.

Төлбөрийн хураамжийг онлайн буюу цахим хэлбэрээр төлөх бол танд ХААН, ГОЛОМТ банкны **онлайн гүйлгээ хийх эрхтэй** карт байх хэрэгтэй. Эдгээр банкны онлайн гүйлгээ хийх эрхтэй карттай бол **Онлайнаар төлөх** товч дээр дарахад ХААН, ГОЛОМТ банкны сонголт гарч ирнэ. Хэрэв ХААН банкны карт ашиглан төлбөр төлөх бол **Хаан**, ГОЛОМТ банкны карт ашиглан төлбөр төлөх бол **Голомт** гэсэн товч дээр дарж сонгосон банкны онлайн банкны системд шилжинэ.

Сонгосон банкны онлайн системд шилжсэний дараа банкны системийн шаардсан мэдээллүүдийг үнэн зөв бөглөж төлбөрийн гүйлгээг хийнэ.

**ХААН БАНК**

**ТӨЛБӨР ХИЙХ / PAYMENT**

Session expired in 9:55

**ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ / ORDER DETAILS**

Дүн: 9000.00 MNT  
 Amount: 9000.00 MNT  
 Гүйлгээний дугаар: 1178003  
 Order ID: 1178003

**ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ / PERSONAL INFORMATION**

Карт эзэмшигчийн нэр: [Redacted]  
 Cardholder name: [Redacted]  
 Картын дээрх нэрээ зөв оруулна уу.

**КАРТЫН МЭДЭЭЛЭЛ / CARD INFORMATION**

Картын дугаар: [Redacted]  
 Card number: [Redacted]  
 Картын ард талд байх 3 орон бүхий CVV код:  
 (Enter the code CVC2/CVV2)  
 Хүчинтэй хугацаа:  
 Expiry Date: 1 - January / 20[Redacted]  
 Гүйлгээ хийх / Submit

ATM-ААС И-ПИН КО  
 ТА ЭНД ДАРЖ

**GOLOMT BANK**

09:58

**ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ / Order information**

Байгууллагын дугаар (Merchant ID): muis  
 Гүйлгээний дүн (Amount): 9,000.00 MNT  
 Нэхэмжлэлийн дугаар (Invoice number): 1178003

**Төлбөрийн картын мэдээлэл / Card information**

UnionPay карт бол энд дарна уу / Using UnionPay card, please click here

Картын дугаар (Card number): [Redacted]  
 Карт эзэмшигчийн нэр (Cardholder name on card): [Redacted]  
 Хүчинтэй хугацаа (Expiration date): MM / YY  
 CVV код (Card Verification Number): [Redacted] CVV код | AmEx?  
 Э-майл (Email): [Redacted]  
 Утасны дугаар (Phone number): [Redacted]

Төлбөр хийх/Do payment

Verified by **MasterCard** **AMERICAN EXPRESS** **SafeKey**  
**VISA** **SecureCode**

Secured by Golomt bank of Mongolia 2008  
 About SSL Certificates

PayBill үйлчилгээгээр төлбөр төлөх нь МУИС-ийн дансанд мөнгө шилжүүлэхийг хэлнэ.

Энэ үйлчилгээний давуу тал нь:

- Бүртгүүлэгч заавал карт ашиглах шаардлагагүй
- Бүртгүүлэгч аль ч банкаар үйлчлүүлэн төлбөрөө төлж болно
- Бүртгүүлэгч банк хоорондын гүйлгээ хийх боломжтой
- Бүртгүүлэгч өөрийн биеэр банкны теллерээр үйлчлүүлэхээс гадна төлбөр төлөх бусад хэлбэрүүдийг ашиглаж болно. Үүнд: интернет банк, смарт банк, mobile банк гэх мэт

Үйлчилгээнд тавигдах шаардлага:

- Бүртгүүлэгч МУИС-ийн ХААН болон ГОЛОМТ банк дахь харилцах дансны дугаарыг мэддэг байх шаардлагатай

МУИС-ийн ХААН болон ГОЛОМТ банктай харилцах данс:

№	Банкны нэр	Дансны дугаар
1	ХААН	5041355868
2	ГОЛОМТ	1102927741



- Шилжүүлэхгүйлгээ хийхэд гүйлгээний утга/төлбөрийн зориулалт хэсэгт бүртгүүлэгчийн БҮТ-ийн бүртгэлийн дугаар -аа заавал бичнэ. Бүртгэлийн дугаарын араас зай аваад дурын текст бичиж болно. Жишээ нь: **17xxxxxxx Регистрийн дугаар Овог Нэр**

**ХААН БАНК** ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ/Deposit slip

Огноо/Date:	Салбар/Branch:	Журнал №/Journal No:	Валют/Currency:	Дэвсгэрт / Denomination	Дэвсгэрт / Quantity	Дүн/Amount
Дансны дугаар/Account Number: <b>5041355868</b>		Валютын код/Currency Code:		1		
Гүйлгээний код/Transaction Code:		Гүйлгээний дүн/Transaction Amount:		5		
Гүйлгээний утга/Description: <b>5XXXXXXX Регистрийн дугаар Овог Нэр</b>				10		
				20		
				50		
				100		
				500		
				1,000		
				5,000		
				10,000		
				20,000		

**GOLOMT BANK** ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ/ DEPOSIT SLIP

Мөнгөн дүн/Amount	Банкны нэр/Bank name	Дансны дугаар/Account number	Төлбөрийн зориулалт /Transaction description	Утасны дугаар/ Phone No
		<b>1102927741</b>		
Мөнгөн нэгж /Currency	Дэвсгэрт / Denomination	Тоо / Quantity	Дүн /Amount	
	1			
	5			
	10			
	20			
	50			
	100			
	500			
	1,000			
	5,000			
	10,000			
	20,000			
	Бүтг /Total			

БҮТ-н системд нэвтэрдэг бүртгэлийн дугаар заавал бичих

БҮТ-н системд нэвтэрдэг бүртгэлийн дугаар заавал бичих

- PayBill үйлчилгээгээр төлбөр төлөхдөө гүйлгээний утга/төлбөрийн зориулалт хэсэгт БҮТ-ийн системд нэвтэрдэг бүртгэлийн дугаар-аа зөв бичсэн тохиолдолд 10-20 минутын дотор таны төлсөн төлбөр МУИС-ийн дансанд орж ирж тухайн мөнгөн дүн Нүүр хуудасны **Боломжит үлдэгдэл** хэсэгт байрлана.

<b>Боломжит үлдэгдэл</b>	<b>10000₮</b>	<b>Төлсөн мөнгө байрлах хэсэг</b>
--------------------------	---------------	-----------------------------------

- Боломжит үлдэгдэлд мөнгөн дүн орж ирсний дараа элсэх эрхээ баталгаажуулах бүрэлдэхүүн/салбар сургуулиа сонгон **Баталгаажуулах** товч дээр дарснаар хэрвээ таны төлсөн төлбөр МУИС-ийн дансанд амжилттай орж ирсэн бол элсэх эрх баталгаажуулалт шууд баталгаажна.

### **Санамж:**

- *Бүртгүүлэгч та элсэх эрхээ баталгаажуулсан бүрэлдэхүүн/салбар сургуулиа баталгаажсан эсэхийг заавал шалгаарай.*
- *Баталгаажуулах төлбөрийг онлайнаар төлөх бол заавал онлайн гүйлгээ хийх эрхтэй картаар төлнө. / E-code заавал авсан байна /*
- *Баталгаажуулах төлбөр төлөх банкны карт нь заавал бүртгүүлэгчийн нэр дээрх карт байх албагүй.*
- *Банкны системээс гүйлгээ амжилттай, амжилтгүй хийгдсэн эсэхэд хариу буцаах бөгөөд зөвхөн амжилттай хариу ирсэн тохиолдолд таны элсэх эрх баталгаажна.*
- *Баталгаажуулах төлбөр төлсөн картаас мөнгө нь хасагдсан боловч бүртгэл нь баталгаажгаагүй тохиолдолд МУИС-ийн Мэдээллийн Технологийн Газар /77307730-1153,1151 МУИС-н номын сангийн 514 тоом/-тай холбоо барина уу.*
- *PayBill үйлчилгээгээр төлбөр төлөх тохиолдолд гүйлгээний утга/төлбөрийн зориулалт хэсэгт БҮТ-ийн системд нэвтэрдэг бүртгэлийн дугаар -аа заавал бичнэ. Хэрвээ бүртгэлийн дугаараа буруу бичсэн тохиолдолд МУИС-ийн Мэдээллийн Технологийн Газар /77307730-1153,1151 МУИС-н номын сангийн 514 тоом/-тай холбоо барина уу.*

## **5. ЭЛСЭХ ЭРХ БАТАЛГААЖСАН ЭСЭХИЙГ ШАЛГАХ**

Төлбөрөө төлж элсэх эрхээ баталгаажуулсан тохиолдолд дараах мэдэгдэх хэсэг гарч ирэх бөгөөд элсэгчийг бүртгэх мэдээлэлтэй танилцана. Элсэгч өөрийн элсэн орсон бүрэлдэхүүн/салбар сургуульдаа бүртгүүлэхээс өмнө **Бүртгэлийн маягт бөглөх** хэсэг дээр дарж маягтыг заавал бөглөсөн байх шаардлагатай.



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

**Аав овогтой ХҮҮ та ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР** бүрэлдэхүүн/ салбар сургуульд элсэх эрхээ баталгаажуулсан байна.

МУИС-д суралцах болсон танд баяр хүргэе.

МУИС-ийн элсэлтийн комисс

Та бүртгэлийн цахим маягт бөглөж, дараах бичиг баримтыг бүрдүүлэн журамд заасан хугацаанд /2017 оны 08 дугаар сарын 08-наас 08 дугаар сарын 25-ны хооронд/ ажлын цагаар бүрэлдэхүүн/салбар сургуулийн сургалтын албанд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ үү. Үүнд:

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын (ар, өвөр тал нэг нүүрт) хамт;
- Танилцаж баталгаажуулсан МУИС-д суралцах гэрээ (элсэлтийн системээс татаж авах);
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичиг, хуулбарын хамт);
- ЭЕШ-ын батламж, хуулбарын хамт;
- Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхийн шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (сүүлийн 3 сард авахуулсан);

Эдгээр бичиг баримтыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.

Та МУИС-д суралцах гэрээг энд дарж татаж авна уу.

Татах

Бүртгэлийн маягт бөглөх

Дарах

Элсэгчийг  
бүртгэх  
мэдээлэл

### Санамж:

- Бүртгүүлэгч та элсэх эрхтэй бүрэлдэхүүн/салбар сургуулиа баталгаажсан эсэхийг заавал шалгаарай.